



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/90/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймгийн Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg@audit.gov.mn

Аудитор: Ц.Энхтуяа

Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.01.28 № 1-6/176

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛААНБАДРАХ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Н.МӨНХЦАЦРАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Мөнхцацралд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 1 -ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК-ний аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв нь сум орон нутгийн хүн амын хэрэгцээнд нийцсэн түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй, цаг алдалгүй чанартай, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 292,428.4 мянган төгрөгөөс тооцон 5,848.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,797.1 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------|-----------------|------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 526.9 | - | (526.9) |
| Бараа материал | 31,194.2 | 54,254.2 | 23,060.0 |
| Үндсэн хөрөнгө | 362,448.7 | 342,651.6 | (19,797.1) |
| Нийт хөрөнгө | 394,169.8 | 396,905.8 | 2,736.0 |
| Өр төлбөр | 219.0 | - | (219.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 393,950.9 | 396,905.8 | 2,954.9 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 394,169.8 | 396,905.8 | 2,736.0 |

Ажилчидтай холбоотой 74.3 мянган төгрөгийн, бусад зардлын тооцооны 357.6 мянган төгрөгийн, хувь хүнтэй холбоотой 95.0 мянган төгрөгийн авлага тус тус барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал 2,514.9 мянган төгрөгөөр, эм боох материал 18,203.5 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 2,932.9 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 1,646.5 мянган төгрөгөөр, түлш шатахуун 26,863.4 мянган төгрөгөөр, хүнсний материал 6,595.3 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 6,599.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж нийт 42,295.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 23,060.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө данс нь 4.724.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр бэлтгэж, 11,890.7 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар авч 36,411.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зардал тооцоноос нийт дүнгээр 19,797.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хувь хүмүүст өгөх 219.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулж ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үндсэн хөрөнгө шинээр бэлтгэсэн, хуримтлагдсан үр дүнгээс хамаарч 2,954.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 294,009.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 292,428.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 99.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|------------------|------------------|------------------|-------------|
| Улсын төсвөөс санхүүжих | 267,605.6 | 267,605.6 | - | 100.0 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 11,408.0 | 11,408.0 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,995.7 | 13,414.8 | (1,580.9) | 89.5 |
| Нийт дүн | 294,009.3 | 292,428.4 | (1,580.9) | 99.5 |

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 1,580.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн нь эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо төлөвлөгөөнд хүрээгүй төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 294,009.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 292,428.4 мянган төгрөг байгаа нь цалингийн зардлыг 8,181.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,243.6 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 228.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 281.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 131.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 66.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 34.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласнаас шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 942.4 мянган төгрөгийн санхүүжилт орсныг урсгал засварын зардалд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 1 горим сорил хэрэгжүүллээ.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалуудыг дансны ангиллын дагуу бүртгээгүй байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Дансны ангилал буруу бүртгэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.16 “*Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө.*” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 31,721,127.78 | 54,254,194.71 |
| 33 | АВЛАГА | 526,934.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 74,340.00 | - |
| 335 | Бусад авлага | 452,594.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 357,594.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 95,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 31,194,193.78 | 54,254,194.71 |
| 351 | Түүхий эд материал | 7,308,605.86 | 17,011,350.51 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,026,913.06 | 7,816,344.07 |
| 35130 | Эм боох материал | 281,692.80 | 9,195,006.44 |
| 354 | Хангамжийн материал | 23,885,587.92 | 37,242,844.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 504,100.00 | 1,933,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 844,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,541,780.42 | 11,708,210.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,118,961.30 | 992,022.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,720,746.20 | 21,765,312.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 362,448,700.34 | 342,651,611.35 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 362,448,700.34 | 342,651,611.35 |
| 392 | Биет хөрөнгө | 357,780,700.34 | 337,983,611.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 286,312,285.00 | 296,302,985.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (9,110,012.76) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 64,033,990.00 | 64,033,990.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,176,635.45) | (41,129,132.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 106,605,320.56 | 110,145,320.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (80,025,051.11) | (90,368,353.30) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,360,540.68 | 17,444,540.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,991,951.50) | (12,076,576.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,084,975.67 | 10,084,975.67 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,422,773.51) | (7,344,125.83) |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,668,000.00 | 4,668,000.00 |
| 39301 | Програм хангамж | 561,000.00 | 561,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (561,000.00) | (561,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,668,000.00 | 4,668,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 394,169,828.12 | 396,905,806.06 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 218,950.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 218,950.00 | - |
| 413 | Өглөг | 218,950.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 218,950.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 218,950.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 393,950,878.12 | 396,905,806.06 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 393,950,878.12 | 396,905,806.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 171,346,214.98 | 171,346,214.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 171,346,214.98 | 171,346,214.98 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 27,281,040.15 | 30,235,968.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 27,281,040.15 | 27,281,040.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,954,927.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 195,323,622.99 | 195,323,622.99 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 394,169,828.12 | 396,905,806.06 |


Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 281,780,395.12 | 306,537,531.61 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 49,218,456.12 | 13,166,771.61 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 49,218,456.12 | 13,166,771.61 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 48,928,456.12 | 13,166,771.61 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 48,928,456.12 | 13,166,771.61 |
| 120006 | Газрын тосны орлого | 290,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 904,339.00 | 25,765,160.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 231,657,600.00 | 267,605,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 904,339.00 | 942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 904,339.00 | 942,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 11,408,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 11,408,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 13,414,760.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 13,414,760.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 220,483,314.08 | 303,582,603.67 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 220,483,314.08 | 303,582,603.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 223,045,014.08 | 293,119,944.67 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 133,210,527.40 | 170,162,098.00 |
| 210101 | Үндсэн цалин | 127,924,191.40 | 170,162,098.00 |
| 210104 | Урамшуулал | 5,286,336.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 8,464,785.00 | 22,070,533.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,685,164.00 | 15,432,823.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 568,516.00 | 1,585,633.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 710,644.00 | 1,464,587.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 136,405.00 | 326,135.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,364,056.00 | 3,261,355.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,892,969.00 | 8,694,010.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,612,969.00 | 2,259,010.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,950,000.00 | 6,050,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 385,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,633,445.58 | 18,631,644.42 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,413,960.00 | 1,775,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,601,635.58 | 13,646,970.42 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,641,000.00 | 1,969,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 356,850.00 | 935,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 304,834.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 620,000.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 13,687,451.03 | 17,754,776.16 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,185,519.33 | 11,260,032.96 |
| 210502 | Хоол, хүнс | 4,556,051.70 | 5,167,193.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 945,880.00 | 1,327,550.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,311,820.00 | 2,099,276.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 534,126.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,311,820.00 | 1,565,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 891,500.00 | 869,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 891,500.00 | 869,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,264,370.00 | 12,829,957.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,148,362.00 | 12,496,037.00 |

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|---------------------|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 160,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,008.00 | 73,920.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,688,146.07 | 40,008,650.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,698,710.00 | 3,596,861.10 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,989,436.07 | 36,411,788.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | (2,561,700.00) | 10,462,659.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 10,462,659.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,462,659.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 90.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 90.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | (2,561,700.00) | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | (2,561,700.00) | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 61,297,081.04 | 2,954,927.94 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 290,000.00 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 290,000.00 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (290,000.00) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 61,007,081.04 | 2,954,927.94 |



Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит


4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>235,061,639.00</u> | <u>293,370,760.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 235,061,639.00 | 293,370,760.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 231,657,600.00 | 267,605,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,404,039.00 | 942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,404,039.00 | 942,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 11,408,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 11,408,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 13,414,760.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 13,414,760.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>233,701,639.00</u> | <u>293,370,760.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 233,701,639.00 | 293,370,760.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 233,443,410.00 | 282,908,101.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 146,589,492.00 | 170,323,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 139,327,731.00 | 145,800,135.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 14,287,483.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,598,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,261,761.00 | 7,637,877.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 18,260,000.00 | 21,685,939.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,340,000.00 | 15,007,509.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,480,000.00 | 1,626,353.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,265,192.00 | 1,464,587.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 296,000.00 | 326,135.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,878,808.00 | 3,261,355.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,577,969.00 | 10,147,910.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,612,969.00 | 2,262,910.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,600,000.00 | 7,500,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 365,000.00 | 385,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,459,544.00 | 25,899,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,801,310.00 | 2,210,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,276,434.00 | 19,167,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,480,000.00 | 1,969,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 901,800.00 | 1,623,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 929,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 22,025,000.00 | 28,469,080.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,173,327.00 | 19,744,880.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,891,195.00 | 5,247,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 960,478.00 | 3,476,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,238,580.00 | 6,824,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 720,200.00 | 3,882,400.00 |
| 210602 | Тавилга | 273,000.00 | 740,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,245,380.00 | 2,202,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 933,500.00 | 869,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 933,500.00 | 869,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,829,195.00 | 12,564,320.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 11,544,713.00 | 12,230,400.00 |

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|------------------------------|----------------------|
| | үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 160,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,482.00 | 73,920.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,530,130.00 | 6,124,117.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,530,130.00 | 6,124,117.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 258,229.00 | 10,462,659.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 258,229.00 | 10,462,569.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 90.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>1,360,000.00</u> | = |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,360,000.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,360,000.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,360,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,360,000.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(1,360,000.00)</u> | = |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 62,000.00 | - |



Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3.1.1 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 166,678,214.98 | - | (1,712,515.58) | 164,965,699.40 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 166,678,214.98 | - | (1,712,515.58) | 164,965,699.40 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 61,007,081.04 | 61,007,081.04 |
| 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 171,346,214.98 | 195,323,622.99 | 27,281,040.15 | 393,950,878.12 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 171,346,214.98 | 195,323,622.99 | 27,281,040.15 | 393,950,878.12 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 171,346,214.98 | 195,323,622.99 | 27,281,040.15 | 393,950,878.12 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 2,954,927.94 | 2,954,927.94 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 171,346,214.98 | 195,323,622.99 | 30,235,968.09 | 396,905,806.06 |

4417144353
E:OAO056 9025707

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|--|-----------------------|----------------|-----------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 294,009,300.00 | 292,428,360.00 | (1,580,940.00) | 99.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 294,009,300.00 | 292,428,360.00 | (1,580,940.00) | 99.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 294,009,300.00 | 281,965,701.00 | (12,043,599.00) | 95.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 178,505,000.00 | 170,323,495.00 | (8,181,505.00) | 95.4 |
| 210101 | Үндсэн цалин | 147,660,000.00 | 145,800,135.00 | (1,859,865.00) | 98.7 |
| 210102 | Нэмэгдэл | 17,625,000.00 | 14,287,483.00 | (3,337,517.00) | 81.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,420,000.00 | 2,598,000.00 | 178,000.00 | 107.4 |
| 210104 | Урамшуулал | 10,800,000.00 | 7,637,877.00 | (3,162,123.00) | 70.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,929,500.00 | 21,685,939.00 | (2,243,561.00) | 90.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,273,300.00 | 15,007,509.00 | (1,265,791.00) | 92.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,914,100.00 | 1,626,353.00 | (287,747.00) | 85.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,531,200.00 | 1,464,587.00 | (66,613.00) | 95.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 382,800.00 | 326,135.00 | (56,665.00) | 85.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,828,100.00 | 3,261,355.00 | (566,745.00) | 85.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,148,000.00 | 10,147,910.00 | (90.00) | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,270,000.00 | 2,262,910.00 | (7,090.00) | 99.7 |
| 210302 | Түлш, халаалт | 7,500,000.00 | 7,500,000.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 378,000.00 | 385,000.00 | 7,000.00 | 101.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,127,400.00 | 25,899,440.00 | (227,960.00) | 99.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,100,000.00 | 2,210,740.00 | 110,740.00 | 105.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,167,400.00 | 19,167,400.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,160,000.00 | 1,969,000.00 | (191,000.00) | 91.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,700,000.00 | 1,623,200.00 | (76,800.00) | 95.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 929,100.00 | (70,900.00) | 92.9 |
| 2105 | Нормативт зардал | 28,750,200.00 | 28,469,080.00 | (281,120.00) | 99.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,750,200.00 | 19,744,880.00 | (5,320.00) | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 5,500,000.00 | 5,247,400.00 | (252,600.00) | 95.4 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,500,000.00 | 3,476,800.00 | (23,200.00) | 99.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,760,000.00 | 5,882,400.00 | (877,600.00) | 87.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,000,000.00 | 3,882,400.00 | (117,600.00) | 97.1 |
| 210602 | Тавилга | 1,500,000.00 | 740,000.00 | (760,000.00) | 49.3 |
| 210604 | Урсгал засвар | 1,260,000.00 | 1,260,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,000,000.00 | 869,000.00 | (131,000.00) | 86.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 869,000.00 | (131,000.00) | 86.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,630,400.00 | 12,564,320.00 | (66,080.00) | 99.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,230,400.00 | 12,230,400.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | 100,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 73,920.00 | (36,080.00) | 67.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 15,000.00 | - | (15,000.00) | - |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | - | (15,000.00) | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,158,800.00 | 6,124,117.00 | (34,683.00) | 99.4 |

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЭМТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|---|----------------|----------------|----------------|-------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,158,800.00 | 6,124,117.00 | (34,683.00) | 99.4 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 294,009,300.00 | 292,428,360.00 | (1,580,940.00) | 99.5 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 267,605,600.00 | 267,605,600.00 | - | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 267,605,600.00 | 267,605,600.00 | - | 100.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 11,408,000.00 | 11,408,000.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 11,408,000.00 | 11,408,000.00 | - | 100.0 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 14,995,700.00 | 13,414,760.00 | (1,580,940.00) | 89.5 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,995,700.00 | 13,414,760.00 | (1,580,940.00) | 89.5 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 18.00 | 18.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 12.00 | (1.00) | 92.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 5.00 | 1.00 | 125.0 |

4417144353
 ENOA0056 9025707

4.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|-------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 942,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 942,400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 942,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 942,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 942,400.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 942,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 942,400.00 |

